



**ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ, “МОНГОЛЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО” ТББ-ЫН ХООРОНД ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2025 он**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ, “МОНГОЛЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО” ТББ-ЫН ХООРОНД ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2026.01.02

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

1.1. Барилга, хот байгуулалтын яам болон “Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын хооронд “Барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх” 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2023/132 дугаар гэрээг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

2.1. Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгов.

үндэслэл болгов.

Гурав. Танилцуулга

3.1. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх ажлын хүрээнд “Барилгын материалын үйлдвэрлэл, эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах” чиг үүргийг “Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ хийж гүйцэтгэхээр 2023.05.30-ны өдрийн 2023/132 тоот гэрээг 2 жилийн хугацаатай шинэчлэн байгуулсан.

Хууль тогтоомжоор шилжүүлэн авч, үйлчилгээ үзүүлж буй эрх шилжүүлсэн шийдвэрүүд:

Хүснэгт 1

Бүлэг, зүйл	Хэсэг, заалт, дэд заалт
1. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль	
19 дүгээр зүйл. Төрийн байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх	19.1. Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.
2. Барилгын тухай хууль	
Гуравдугаар бүлэг Барилгын үйл ажиллагааны үндсэн шаардлага: 13 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага	Энэ хуулийн 13.5-т Барилгын материалын үйлдвэрлэл, олборлолт болон барилгын материал, бүтээгдэхүүнд тавих нарийвчилсан шаардлагыг барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулна.
19 дүгээр зүйл. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	Энэ хуулийн 19.1.4-д заасан ангилалд хамаарах даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал түүний түүхий болон шатамхай, химийн хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

Тавдугаар бүлэг Барилгын салбарын удирдлага, зохицуулалт 33 дугаар зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 34 дүгээр зүйл. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг	33.1.1. барилгын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх; 34.1.7. барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
Зургаадугаар бүлэг Барилгын үйл ажиллагаанд оролцогч 36 дугаар зүйл. Иргэн, төрийн бус байгууллагын оролцоо	36.1. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 19.1.4, 34.2, 44.7-д заасны дагуу шилжүүлсэн төрийн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно.
3. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай Засгийн газрын шийдвэр	
Тогтоолын огноо, дугаар	Товч утга
2012.08.07 Дугаар 250	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай /Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох/
3. Сайдын тушаал	
Гэрээний дугаар 2023/132	Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

4.1. Төлөвлөгөөний хэрэгжилт:

Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нийт 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг тусгасан хэрэгжүүлсэн.

Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар **85.6 %-тай** үнэлэгдэж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилт:

Хүснэгт 2

№	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар			ҮБ	%
			85 буюу түүнээс дээш "бүрэн хангалттай"	70-85 хангалттай	70 хүртэл хангалтгүй		
1	5	16	7	1	1	7	85.6%

Зорилтын хэрэгжилт арга хэмжээ тус бүрээр:

Хүснэгт 3

Д/д	Үндэслэл	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Биелэлт	
-----	----------	------------------	-----------------	---------	--

Барилга, барилгын материалын үйлдвэрийн хууль тогтоомж, эрх зүйн болон норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх					
1.1.	“Барилгын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн заалтуудыг үйлдвэрлэгч идтэй хамтран хэрэгжүүлж ажиллана.	Материалын материалын үйлдвэрүүдэд хуулийн сурталчилгаа хийсэн байна.	Хуулийг хэрэгжүүлсэн байна.	Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага заалтын хүрээнд барилгын материалын чанар стандартыг хэрэгжүүлэх ажлыг Хот, Байгуулалт, Барилга, Орон Сууцжуулалтын Яам болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллалаа. Барилгын материал үйлдвэрлэгчидтэй хамтын ажиллагааг өргөжүүлж дотоодын барилгын материал үйлдвэрлэгчдийн материалыг танилцуулах, хэрэглээг сурталчлах ажлыг нийт дотоодын үйлдвэрлэгч компаниудтай хамтран 23 удаа зохион байгуулж үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний танилцуулга, технологийн шинэчлэл, шинэ иновацийн тухай танилцуулж, туршлага солилцож ажиллалаа. 2023 -2024 онуудад Холбоо БНСУ-ын Даевоо ХХК-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд аж ахуй нэгжүүдээ зохион байгуулан 8 -15 захирал, технологич, мэргэжилтэй ажилчдыг Солонгос Улсад очиж бетон зуурмаг, чулуу бутлан ангилах, химийн нэмэлт, мяндас полимер арматурын үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцуулж шинэ технологи, инноваци, үйлдвэртээ хэрэгжүүлж болох үйл ажиллагааг танилцуулах ажил зохион байгууллаа. Вьетнам улсын ус үл нэвтрүүлэх химийн нэмэлт бодисын сурталчилгаа, дулаан тусгаарлах материал -Хөөсөн полистирол хавтан, “МУ-ын ЖДҮ-ийн хүлэмжийн хийг бууруулах технологийн оношилгооны зөвлөх үйлчилгээ”-г танилцуулах үйл ажиллагааг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж, тухайн чиглэлийн үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилтан болон удирдах ажилтануудыг оролцуулж санал солилцлоо. Бетон зуурмагийн үндсэн дүүргэгч материалын чанар стандартыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд	ҮБ

				Ашигт малтмалын газрын Эрдэс Баялагийн Зөвлөлд хамтран ажиллаж Зөвлөх О.Лхагвадоржийг зөвлөлийн гишүүнээр ажиллуулаж 2025 оны хүрээнд зөвлөл 12 удаа хуралдаж 11 байгууллагын ТЭЗҮ, нөөцийн мэдээлэлийг хурлаар хэлэлцүүлээ. Биелэлт 100 хувь	
1.2.	“Барилгын тухай” хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.14 дэхь заалтыг БХБЯамтай байгуулсан гэрээний хүрээнд хийж гүйцэтгэнэ.	2020 онд БХЯамтай хийсэн гэрээний үүргээ биелүүлсэн байна.	Барилгын материалын үйлдвэрүүд тусгай зөвшөөрлийн эрхээ сунгуулах ба шинээр авсан байна.	Уг ажлын хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 128 аж ахуй нэгжийн хүсэлтийг хянан үзэж, нийт 118 /шинээр 99 аж ахуй нэгж, сунгалтаар 1 аж ахуй нэгж, дахин шинээр 16 аж ахуй нэгж, нэмэлтээр-2/ хүсэлтийг Сайдын 24 удаагийн тушаалаар баталгаажуулан хүргүүлээ. 2 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөл цуцлагдсан. 1 аж ахуйн нэгж Оноосон нэрээ өөрчилсөн. Ажлын төрлөөр ангилбал: МҮ-1.1 технологийн иж бүрэн дамжлага бүхий цементийн үйлдвэр 1, МҮ-2.1 Дүүргэгч материал элс, хайрга, гаралтай чулуу бутлан ангилах, байгалийн чулуу олборлох, боловсруулах үйлдвэр 10, МҮ-3.3 хөөсөн полистрол хавтан эдлэлийн үйлдвэр, дулаан тусгаарлах материалын үйлдвэр 9*, МҮ-3.7 байгалийн болон зохиомол хөнгөн дүүргэгч бүхий дуу дулаан тусгаарлагч гулдмай хавтгаалжийн үйлдвэр 2, МҮ-4.1.1-10, МҮ-4.2.2-48 буюу бетон зуурмагийн үйлдвэр болон төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүд нийт 58, МҮ-5.1.1- ган туйван, бетон бүтээцийн мяндас полимер арматур катангийн үйлдвэр 3, МҮ-7.1.1 бетоны химийн болон идэвхит эрдэс нэмэлтийн үйлдвэр 2, МҮ-8.1.1 керамик тоосго, гулдмайн үйлдвэр 3, МҮ-11.1.1 эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын үйлдвэр 23, МҮ-6.1.1-хуванцар хоолойн -2, МҮ-5.2.1-ган бөмбөлөгийн, МҮ-3.2.1- 1 аж ахуй нэгж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдэд экспертийн баг ажиллахдаа Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь, Завхан, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн болоод Улаанбаатар хотын 125 аж	100

				ахуй нэгжид зөвшөөрлийн үйл ажиллагааны магадлан хяналт хийж үйлдвэрүүдэд зөвөлгөө өглөө. Биелэлт 100 хувь	
1.3	Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг https://mcis.gov.mn системийг хэрэгжүүлэх, өргөжүүлэх, сурталчлах ажлыг хийж гүйцэтгэнэ.	БХБСайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн 147 дугаар тушаал өөрлөгдөж Монгол Улсын Хот байгуулалт, барилга Орон Сууцжуулалтын Сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 36 дугаар тушаал "Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага батлах" тухай хүрээнд ажиллах.	Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн нэгдсэн цахим системийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 36 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд цахим системтэй ажиллах зааврыг тухай бүр барилгын материал үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдэдээ email хаягаар нь илгээхээс гадна өөрийн байгууллагын пэйж хуудсанд тавьсан. Холбоо аж ахуйн нэгж, байгууллагатай эргэх холбоогоор цахим системээр тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа бүрэн хангагдан ажиллаж байна. 2025 онд барилгын материал үйлдвэрлэл эрхэлдэг нийт 120 гаруй компани цахим системээр материалаа илгээж барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн эрхээ сунгуулж, мөн шинээр авлаа. Биелэлт 100 хувь	100
1.4.	Барилгын тухай" хуулийн 34 дүгээрийн зүйлийн 34.1.15 дахь заалтыг БХТөв ТӨҮГазартай хамтран хэрэгжүүлнэ.	Барилгын материалын үйлдвэрүүд Технологийн Заавар батлуулсан байна.	Үйлдвэрүүд технологийн зааварыг улсын Тенологийн зааварыг бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулж, тусгай зөвшөөрөл олгох ажиллагаанд мөрдөж	"Барилгын тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.15 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд дотоодын барилгын материал үйлдвэрлэгчдтэй хамтран ажиллаж нийт 17 үйлдвэрлэгчдийн технологийн зааварт шинэчлэн хийж хамтран ажиллалаа. Энэ ажлын хүрээнд бүтээгдэхүүний чанар, стандартыг хангуулах ажлыг БХТөв, БАК, БХҮНТөвийн баталгаажуулалтын албадуудтай хамтран ажиллаж байна. Бид барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааварт зөвөлгөө өгөх, бүтээгдэхүүн баталгаажуулах ажилд зөвлөмж өгөх, лабораторийн туршилтыг дүгнэх зэрэг ажлыг мэргэжлийн баталгаажуулалтын	100

			ажилласан байна.	албатай хамтран Зөвлөх инженерүүдээ ажиллуулж байна. БНХАУ-ын Үндэсний стандарт GB/T18583-2008, GB/T 30982-2014, GB/T 33372-2020-“Дотоод засал, чимэглэлийн материалын цавуунд агуулагдах хортой бодисын хэм хэмжээ”-тэй холбоотой стандартыг боловсруулан БХТ-д хүлээлгэн өгсөн. Биелэлт 100 хувь	
1.5.	Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх ажилд санал хүргүүлж хамтран ажиллана. /ЗГҮАХХАХТ //3.7.13.4/	Орон нутагт дүүргэгч материалын үйлдвэрүүд өөрийн нөөц ордтой болсон байна.	Бетоны үндсэн түүхий эд элс хайрга дайрганы нөөц нэмэгдсэн байна. АМГТГазрын Эрдэс баялагийн зөвлөлтэй хамтран ажилласан байна.	2025 онд Аж үйлдвэр Эрдэс Баялагийн яамны Ашигт малтмал газрын тосны газрын дэргэдэх Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөл 27 удаа хуралдсан байна. Тус хурлуудаар материалын орд газрын олборлолт явуулж байгаа 238 аж ахуй нэгжүүдийн техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж баталсан байна. Шохойн чулууны 41, Тоосгоны шаврын 34, Өнгөлгөөний чулууны 16, Барилгын болон технологийн элсний 25, Элс хайрганы хольцын 51, Барилгын чулуу /дайрганы/ 92, Перлитын 1, Базальтын 2, Нийт 238 орд газрын олборлолт шинээр болон үргэлжүүлэн үйл ажиллагаа нь цаашид хэрэглэхээр ТҮЗЭ-ээ хэлэлцүүлсэн ба хэлэцүүлэхээр оруулсан байна. Эндээс харахад бетоны дүүргэгч материалын зориулалттай Барилгын чулууны / дайрганы /92/, элс хайрганы хольцын /51/, барилгын болон элсний /25 ордууд зонхилж байгаагаас харахад бетон дүүргэгч материалын зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хангахад бодлого чиглэгдэж байгааг харуулж байна. Биелэлт 100 хувь	100
1.6	Барилгын материалын чанар аюулгүй байдлын техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулж дуусган	Техникийн баримт бичгийг боловсруулсан байна.	Засгийн газраар батлуулсан байна.	БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ” -ыг 2025 оны 12 дугаар сарын 17-ний өдөр Засгийн газраар батлагдсан. Биелэлт 100 хувь	100

	БХТөв БХБЯамны ББМҮХЗГаза ртай хамтран батлуулна.				
2..Барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны удирдлага, хяналтын тогтолцоог сайжруулах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын хүрээнд:					
2.1	Барилгын материалын үйлдвэрлэлийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтыг зохион байгуулна.	Үйлдвэрүүдтэй хамтран мэргэжилтэй ажилтан бэлтгэх, үйлдвэрийн дадлагажуулах сургалтыг зохион байгуулсан байна.	Үйлдвэрүүд мэргэжлийн ажилтангаар хангагдана.	Барилгын материалын үйлдвэрлэлийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд "Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт" чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөрийг "Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтэд үнэлүүлэн баталгаажуулсан ба 10 удаагийн сургалтыг зохион байгуулж 80 хүн сургасан байна. Үүнд: Бетон зуурмаг хийц эдлэлийн үйлдвэрийн лаборант - 30 Төмөр бетон хийц эдлэлийн лаборант - 25 Зуурагч холигч тоног төхөөрөмжийн оператор, засварчин -25 тус тус суралцсан байна. 2025 онд Бетон зуурмаг, бетон эдлэлийн үйлдвэрийн лаборантаар нийт 55 хүн бэлтгэсэн байна. Үүнд: "Бодь могой трейд", "Шар монгол", "Оргил зуурмаг", "Хүрмэн зээрд", Тэргүүн конкрет", "Эрин интернэйшнл", "Эмирайлд плейс", "Стөүнхиж", "УБ-БҮК", "Мейжор саплай", "Их өргөө зуурмаг", "Микс про", "Сүх индэр", "Өв идэр", "Плас саплай", "Каяак конкрет", "Монфрукт", "Хөвсгөл зам", "Мөнх өсөн нэмэх", "Гэрэлт цагаан дөш", "Зэвсэгт хүчний 017-р анги", "Хаяашия Монгол", "Билгүүн Монгол", "Энх-өглөө", "Ганбагана конкрет", "Мөрөн бетон" "Кроун конкрет", "Хүрмэн зээрд", "Товгор сайр", "ЗХ нэгтгэл", "Гал мөнх карьер", Стар конкрет", "Ноц бетон зуурмаг", "Броун хайт биг констракшн", "зэрэг ХХКомпаниуд бүрэн хамрагдсан байна. 2025 онд -"Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт"-ын мэргэжлээр"Товгор сайр", "Хансай зуурмаг", "Ремикон", "Оргил зуурмаг", "Ганбагана конкрет", "Бест бетон", "Еверест конкрет", "Стийл ребар", "Ноц бетон зуурмаг", "Хөвсгөл зам", "Мейжор саплай", "Их өргөө зуурмаг"	100

				“БМК” ХХКомпаниуд аас 25 хүн ажилтан хамрагдсан. Биелэлт 100 хувь	
3. Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан дотоодын барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих чиглэлээр:					
3.1	Цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх бодлогыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, мэргэжлийн зөвлөмжөөр хангаж ажиллана. МУХТЖҮЧ-3.2.4, ЗГҮАХ-АХТ-3.7.11.1, 3.7.11.2, 3.7.11.3	Дотоодын үйлдвэртэй хамтран ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан байна.	Дотоодын үйлдвэрүүдийн түүхий эдийн нөөц нэмэгдэж үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Дотоодын барилгын материалын үйлдвэрүүдийг дэмжих, тэдгээрт үргэлж зөвлөмж өгөх хамтран ажиллах бодлогоо хэрэгжүүлэхэд ажиллаа. “Эм эн жи металл” ХХК арматурын үйлдвэр, “Корапластик” ХХК, “Супер хучилт” ХХК металл хийц эдлэлийн үйлдвэр шинээр ашиглалтанд орууллаа.” Дөл түшиг” ХХК, . “Төгс засал” ХХКомпаниудын ган туйвангийн үйлдвэр, үйлдвэрийн өргөтгөлийн ТЭЗҮ-г Зөвлөх инженерүүдийн хамт боловсруулж БХТ-ийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ. Улсын хэмжээнд 2025 онд нийт 548,72 мян. тонн арматур хэрэглэсний 124,93 мян. тонн дотоододын үйлдвэрлэгчид, 423,79 мян. тонныг импортлосон байна. Биелэлт 100 хувь	ҮБ
3.2.	Улсын хэмжээнд ажиллаж байгаа болон шинээр баригдаж байгаа, тоног төхөөрөмжүүдээ суурилуулж байгаа гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн	Дархан, Эрдэнэт, Дорноговь аймгуудад баригдаж байгаа ашиглалтанд орохоор төлөвлөгдсөн гангийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай газар дээр танилцаж холбогдох асуудлаар төрийн байгууллагуу	Дотоодын гангийн үйлдвэрүүд ажиллаж дотоодын зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэгдсэн байна.	Дотоодын барилгын материалын үйлдвэрүүдийг дэмжих, тэдгээрт үргэлж зөвлөмж өгөх хамтран ажиллах бодлогоо хэрэгжүүлэхэд ажиллаа. Биелэлт 100 хувь	0 Гангийн үйлдвэрт ажиллаагүй байна.

	зөвлөмж хүргүүлж ажиллана. /ЗГҮАХХАХТ 3.7.13.1/, ("Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөн ий 5.1.2, 5.1.3)	дад санал хүргүүлж хамтран ажиллана.			
3.3.	Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтанд оруулах ажлын хүрээнд мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд хамтран ажиллана. /ЗГҮАХХАХТ 3.7.13.2/	Мэргэжилт эй ажилтан бэлтгэгдсэ н байна.	Мэргэжилт эй ажилтан бэлтгэгдэ ж эхэлсэн байна.	"ШИЛЭН ХИЙЦ" ХХК нь шилний иж бүрэн лаборатори ашиглалтанд, СХЗГ- н итгэмжлэлийн албанаас итгэмжлэгдсэн. Тус лабораторийн үйл ажиллагаа, шинжилгээний төрлийг хаалга, цонх үйлдвэрлэгчдэд танилцуулан, цонх, хаалга үйлдвэрлэгч 24 аж ахуй нэгжүүдийн төлөөлөлийг оролцуулан хамтарсан сургалт зохион байгууллаа. Биелэлт 100 хувь	ҮБ
3.4.	Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмжий г суурилуулах ажилд мэргэжлийн зөвлөгөө өгч	Үйлдвэрийн технологийн хүрээнд зөвлөж хамтран ажилласан байна.	Үйлдвэрий г мэдээлэлэ эр хангаж төрийн бодлогыг хамтран хэрэгжүүл сэн байна.	Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого /ЗГ-ын 2019 оны 70 дугаар тогтоол/-ын 2.2.5 заалтын хүрээнд Налайх, Багахангай дүүрэгт ашиглалтанд орсон арматурын үйлдвэрт мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллалаа. 2025 оны 10 сард Ховдын цементийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөмж өгч, баруун аймгийг цементээр хангах ажлыг сайн гүйцэтгэж байгаад нь талархал	ҮБ

	хамтран ажиллана. /ЗГҮАХХАХТ 3.7.13.3/, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого /ЗГ-ын 2019 оны 70 дугаар тогтоол/-ын 2.2.5			илэрхийллээ. “Вестерн холд” ХХК “нь 2025 онд 160 мян.тн цемент үйлдвэрлэсэн байна. Мөн Улаанбаатар хотод салбар нээж ажиллуулан клинкерээ боловсруулж, 60 мян тонн цемент үйлдвэрлэсэн. Биелэлт 100 хувь	
3.5	Барилгын материалын үйлдвэрүүдэд хог хаягдлыг дахин ашиглах талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж, санал хүргүүлж хамтран ажиллана. /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.21/, /БХБС-ын 2021.07.22			Барилгын материалын үйлдвэрүүдэд хог хаягдлын сургалтыг “Хог хаягдлын Холбоо”-той хамтран зохион байгууллаа. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН)-ийн хэрэгжилтийг дэмжих” төслөөс “Барилгын материалын зардал-өгөөжийн шинжилгээ” сэдэвт судалгааны ажил хийж байгааг дэмжин барилгын материалын үйлдвэрүүдээс судалгаанд 8 компанийг оролцуулан хамтран ажиллаж үр дүнг тайланг гаргаж хүргүүлэв. Монгол Улсад дулаалгын материал үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгчид болон төслийн хүмүүстэй “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” сургалт зохион байгууллаа. Барилгын тухай ерөнхий хууль, зөвшөөрлийн тухай хуулийн өөрчлөлтийн асуудлаар хэлэлцүүлэг 2025.02.21-нд зохион байгуулж, 40 аж ахуй нэгжийн төлөөлөл оролцов. 2026 оны норм, нормативийн төлөвлөгөөнд аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн саналыг хүргүүлэх ажлыг зохион байгууллаа. “Барилгын материалын үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих хөтөлбөр 2025-2028”-ийг боловсруулах ажилд оролцов. Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан Барилгын салбарын төрийн бус байгууллагуудыг чадавжуулах сургалтад 21 аж ахуй	ҮБ

	“Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө” 2021-2030 арга хэмжээний 1.3.1, 1.3.4 дахь заалт/			нэгжийг хамруулав. Хөдөө орон нутгийн ГХБХБГ-н мэргэжилтнүүдийн сургалтад илтгэл тавьж оролцлоо. Биелэлт 100 хувь	
4. Барилгын материалын үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, экспортод гаргах, судалгаа, мэдээллийн чиглэлээр:					
4.1.	Цементийн ханган нийлүүлэлтийн нэмэгдүүлэх, оновчтой сүлжээг бий болгож, нөөц бүрдүүлэх, дотоодын хэрэглээг бүрэн хангаж, экспортод гаргах ажлыг зохион байгуулна.	Цементийн үйлдвэрүүдтэй хамтран ОХУ-д мөрдөгдөж байгаа цементийн ГОСТ-ын стандартыг Стандартын техникийн хороогоор батлуулсан байна.	Цементийн үйлдвэрүүдтэй хамтран ОХУ-д ажиллуулж байгаа төлөөлөгчийг сунган ажиллуулж цемент экспортолх нөхцөлийг бүрдүүлсэн байна	Дотоодын цемент үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүд 2025 онд 2,6 сая тн цемент үйлдвэрлэсэн нь дотоодын хэрэглээг бүрэн хангаж чадлаа. Цементийг экспортод гаргах ажлын хүрээнд экспортлох ажлыг бүрэн зохион байгуулж бэлэн болсон боловч Ковид болон дайны үйл ажиллагаатай холбоотой зогссон болно. Орос улсад мөрдөгдөгдөж байгаа цементийн ГОСТ-ын стандартыг 2025 оны 6 дугаар сард Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулсан болно. Биелэлт 100 хувь	100
4.2.	Экспортлож болох барилгын материалыг импортлогч аж ахуй нэгж, хувь хүмүүстэй хамтран ажиллаж	Үйлдвэрлэгчидтэйгээ хамтран хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж экспортод гаргах боломжтой бүтээгдэхүүни	Судалгаа хийгдсэн байна.	Төв аймгийн Угтаал цайдамын өөхөн чулуу олборлох үйл ажиллагааны явцад гарсан хаягдалыг боловсруулж буй “Хос Монгол” ХХК-ний үйлдвэртэй танилцаж, хамтран ажиллахдаа экспортлох боломжтой талаар зөвөлгөө өгч ажиллав. Ирэх онд үргэлжүүлэн судалгаа хийж ажиллах болно. Биелэлт 100 хувь	70

	судалгаа хийнэ.	й судалгааг хийнэ.			
5. Барилгын материалын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, чанар аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр:					
5.1.	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Итгэмжлэгдсэн лабораториуд болон үйлдвэрүүдийн дотоодын хяналтын лабораториудтай хамтран ажиллаж, зөвлөмжөөр хангаж, туршилтын үр дүнд мониторинг хийж ажиллана.	Итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажилласан байна.	Барилгын материалд тавих чанар стандартын хэрэгжилтийн үр дүн нэмэгдэж, бүтээгдэхүүний лабораторийн туршилтууд сайжирсан байна.	Магадлан хяналтын ажлын хүрээнд хөдөө орон нутгийн ГХБХБГ-ын дэргэдэх лабораториудын үйл ажиллагаатай танилцлаа. Лабораториудын нэгдсэн удирдлагын асуудал шийдэгдээгүй гэдэг шалтгаанаар ихэнх аймгуудын лабораториудын итгэмжлэл сунгагдахгүй байгаа нь аймгуудын материалын үйлдвэрлэл болон бусад үйл ажиллагаанд хүндрэлтэй байгаа талаар орон нутгийн мэргэжилтэнүүд мэдээлэл хийж байсан. Бид шинээр үйлдвэр байгуулахаар хандсан аж ахуй нэгжүүдэд зөвлөгөө өгөхдөө лабораторийн ач холбогдлын талаар тогтмол тайлбарлаж, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг гаргаж өгч ажилладаг болно. Шинэ техник технологи хөгжиж, шинэ бүтээгдэхүүний технологи өргөнөөр орж ирж байгаа өнөө үед тэдгээрийн туршилт шинжилгээ хийх чадамж итгэмжлэгдсэн лабораториудад учир дутагдалтай байгаа нь нийгэмд сөрөг үр дагавар авчрах, шинэ технологи материалыг хэрэглэх боломжийг хааж байна. Биелэлт 100 хувь	ҮБ
5.2.	“Аймгуудын барилгын материалын лабораторийн ажилтныг чадавхижуулахад лаборантийн сургалтыг зохион байгуулж ажиллана.	Аймгуудын лабораториуд лаборантаар хангагдсан байна.	Орон нутгийн Барилгын материалын лабораториудыг мэргэжлийн зөвлөмжөөр хангаж ажилласан байна.	Барилгын материалын чанар стандартыг хангаж ажиллахад барилгын материалын лаборатори хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Тийм учраас манай холбоо барилгын материалын лаборатори байгуулах лабораторитой болоход ямар тоног төхөөрөмжийг авч ашиглаж болох талаар үйлдвэрлэгчидээ үргэлж зөвлөмж хүргүүлж хамтран ажиллаж байна. Аймгуудад ажиллаж байгаа барилгын материалын лабораторийн ажилтныг чадавхижуулах хүрээнд экспертийн баг дараах аймгуудад ажилласан. Үүнд: Говь-алтай, Ховд, Баян-өлгий, Увс, Завхан, Орхон-Уул,	ҮБ

				Сэлэнгэ, Дархан-уул аймгуудын ГХБХБГ-ын мэргэжилтнүүдтэй тус холбооны Гүйцэтгэх захирал МУ-ын Зөвлөх инженер Г.Цэрмаа, Төмөр бетон хийц эдлэлийн МУ-ын Зөвлөх инженер М.Янжинлхам нар хамтран ажиллаж, барилгын материалын үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, лабораторийн лаборант болон үйлдвэрүүдийн технологич, лаборант нарт мэргэжлийн зөвөлгөө өгч чадавхижуулан ажилласан. Биелэлт-100 хувь	
--	--	--	--	--	--

Хэрэгжилт хангалтгүй ажлууд:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 70 хүртэл хувьтай "хангалтгүй" хэрэгжсэн 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.2. Улсын хэмжээнд ажиллаж байгаа болон шинээр баригдаж байгаа, тоног төхөөрөмжүүдээ суурилуулж байгаа гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөмж хүргүүлж ажиллана.

Тав. Дүгнэлт

1. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 85.6 хувьтай үнэлэгдэв.
2. Дээрх үнэлгээ нь 2025 оны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин нь тоо болон чанараар илэрхийлэгдээгүй, үнэлэх боломжгүй арга хэмжээ ихтэй тул тодорхой үнэлэгдэх боломжгүй буюу хийсвэр үнэлэгдэж байна.

3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх ажлын хүрээнд "Барилгын материалын үйлдвэрлэл, эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах" чиг үүргийг "Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2023.05.30-ны өдрийн 2023/132 тоот гэрээг 2 жилийн хугацаатай шинэчлэн байгуулсан нь 2025 онд гэрээ дуусгавар болсон байна.

Зургаа. Санал, зөвлөмж

1. Төлөвлөгөөний хангалтгүй үнэлэгдсэн 3.2 дахь арга хэмжээний биелэлтийг ханган ажиллах;

2. 2026 оны төлөвлөгөөндөө тусгах, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг оновчтой, тодорхой төлөвлөж, тайлан, биелэлтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй уялдуулан тоо, хэмжээ, чанарыг тодотгон тодорхой тайлагнах.

3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх ажлын хүрээнд "Барилгын материалын үйлдвэрлэл, эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах" чиг үүргийг гүйцэтгүүлэх 2023.05.30-ны өдрийн 2023/132 тоот гэрээний биелэлтийг дүгнүүлж ажиллахыг "Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ /Г.Цэрмаа/-д даалгасугай.

4. "Барилгын материалын үйлдвэрлэл, эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах" чиг үүргийг "Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэх 2023.05.30-ны өдрийн 2023/132 тоот гэрээний биелэлтийг дүгнэж, гэрээг "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолыг баримтлан зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн захиргааны

удирдлагын газар /Б.Бат-рдэнэ/, Барилга барилгын материалын бодлого зохицуулалтын газар /Д.Энхбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

Хянасан: Салбарын хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын газрын дарга



Б.Найрамдал

Хянасан: Салбарын хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч



А.Гэрэлт-Од